

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2026/137/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 23</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бүнчинсүрэн</p> <p>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.МӨНХБАТ ТАНАА**

2026.02.05 № 2/144
танай _____-ны № _____-т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Баянхонгор сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2/14 дүгээр тогтоолоор 2025 онд ЗДТГ-т автомашин худалдан авахад 150,000.0 мянган төгрөг батлагдсан байхад 186,700.0 мянган төгрөгөөр, Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх 130,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор сумын 10 дугаар багийн 301, 303, 511, 109 дүгээр байрны гадна фасад, дээврийн засвар"-ын ажлыг 177,590.4 мянган төгрөгөөр батлагдсан төсөвт өртгөөс хэтрүүлэн гэрээ байгуулж хэрэгжүүлсэн.

6726050409
/2026 он/1. бичиг хэргэн тоот/2-а4-
албан тоот.docx

- Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс биеийн тамир уралдаан тэмцээн зохион байгуулахад тайлант онд 17,457.5 мянган төгрөгийн зарцуулсан

- Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж нэмэлт санхүүжилтийн дансанд олгосны хүрээнд 165,770.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Баянхонгор сумын А зэрэглэлийн бүсийн тоосжилтыг бууруулах зорилгоор шаардлагатай газруудад хучилт хийх” төслийг 9 иргэнтэй, мөн 200,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Нэгдсэн эмнэлгийн гадна зогсоолын засвар” төслийг 9 аж ахуйн нэгжтэй тус тус тендер зарлалгүйгээр шууд гэрээг байгуулан хэрэгжүүлсэн.

- Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/130 захирамжаар мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас Ниншягийн олон улсын найрамдалт хотуудын 4 дүгээр форумд оролцоход тийз, замын зардалд 13,481.5 мянга, бэлэг сэлтийн зардалд 12,450.0 мянга нийт 25,931.5 мянган төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалт "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" өрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" 10 дугаар зүйлийн 10.3 дахь "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтууд мөн УСНББОУС-1 Санхүүгийн толилуулга, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээний зардалд 465,840.0 мянган төгрөг батлагдаж 285,373.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 4,679,376.4 мянга, өмнөх оны үлдэгдлээс 1,317,668.5 мянга нийт 5,997,044.9 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,997,044.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.2 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	534,760,032.30	1,191,217,550.71
33	АВЛАГА	93,304,996.00	336,837,393.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,861,028.00	00.00
335	Бусад авлага	89,443,968.00	336,837,393.25
3351	Байгууллагаас авах авлага	73,113,868.00	317,007,293.25
3352	Хувь хүмүүсээс авах авлага	16,330,100.00	19,830,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	441,455,036.30	854,380,157.46
354	Хангамжийн материал	428,343,978.30	846,760,491.26
35410	Бичиг хэргийн материал	45,149,499.11	45,751,875.00
35420	Аж ахуйн материал	311,485,410.25	732,179,547.32
35430	Сэлбэг хэрэгсэл	6,895,000.00	8,467,000.00
35470	Бусад хангамжийн материал	64,814,068.94	60,362,068.94
35600	Мал амьтад	13,111,058.00	7,619,666.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,677,553,684.48	3,244,651,668.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,677,553,684.48	3,244,651,668.93
392	Биет хөрөнгө	2,560,981,684.48	3,158,079,668.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,991,180,654.10	2,254,168,401.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-474,773,494.47	-577,732,351.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,390,000.00	456,090,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-115,245,666.40	-139,046,333.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	608,619,666.93	794,355,566.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-222,770,691.29	-308,120,312.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	279,113,640.66	319,947,640.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-120,292,130.38	-155,149,455.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	542,769,608.00	624,159,268.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-48,618,002.67	-111,200,854.70
39217	Ном	608,100.00	608,100.00
393	Биет бус хөрөнгө	116,572,000.00	86,572,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,500,000.00	-1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	116,572,000.00	86,572,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,212,313,716.78	4,435,869,219.64
413	Өглөг	3,209,012.00	48,275,808.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	12,769,308.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,209,012.00	10,620,000.00
4136	Бусад өглөг	00.00	24,886,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	18,956,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	5,930,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,209,104,704.78	4,387,593,411.24
51	Засгийн газрын хувь оролцоо	3,209,104,704.78	4,387,593,411.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,709,433.09	876,709,433.09
51101	Өмч: - төрийн	876,709,433.09	876,709,433.09
512	Хуримтлагдсан үр дүн	1,967,813,910.83	3,146,302,617.29
51210	Өмнөх үеийн үр дүн	1,967,813,910.83	1,967,813,910.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,178,488,706.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,581,360.86	364,581,360.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,212,313,716.78	4,435,869,219.64

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,195,026,947.18	9,481,509,243.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	649,524,654.18	886,782,607.00
120	Нийтлэг татварын бус орлого	649,524,654.18	886,782,607.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	497,692,670.93	552,127,407.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал	151,831,983.25	334,655,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,545,502,293.00	8,594,726,636.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,573,393.00	2,464,600,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,573,393.00	2,215,196,863.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	249,403,673.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,410,928,900.00	6,130,126,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,410,928,900.00	6,130,126,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,578,842,682.74	8,208,712,598.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,578,842,682.74	6,239,523,511.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,153,418,570.35	6,009,138,368.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,793,852,669.86	2,240,789,534.49
210101	Үндсэн цалин	1,014,780,625.95	1,193,142,796.21
210102	Нэмэгдэл	557,099,124.21	878,119,803.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,044,147.38	110,597,634.95
210104	Урамшуулал	121,928,772.32	58,929,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,936,974.37	277,891,403.29
210201	Тэтгэврийн даатгал	158,882,408.64	190,206,135.20
210202	Тэтгэмжийн даатгал	18,453,109.93	22,613,627.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,697,417.59	12,135,005.58
210204	Ажилгүйдлийн даатгал	8,172,252.58	10,508,452.23
210205	Эрүүл мэндийн даатгал	31,731,785.63	42,428,183.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,332,137.52	128,926,281.11
210301	Гэрэл, цахилгаан	10,637,734.52	21,737,328.11
210302	Түлш, халаалт	98,134,903.00	102,866,569.00
210303	Цэвэр, бохир ус	4,559,500.00	4,322,384.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,550,869,213.37	2,016,961,800.91
210401	Бичиг хэрэг	22,707,600.00	21,365,700.00
210402	Тээвэр, шатахуун	44,799,202.00	42,990,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,921,696.97	22,954,904.00
210404	Ном, хэвлэл	2,693,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,432,900,000.00	1,898,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,710,190.00	13,511,281.00
210408	Бараа материал акталсны зардал	25,137,524.40	18,139,915.91
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,798,870.00	46,506,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	172,000.00	610,500.00
210604	Урсгал засвар	120,626,870.00	45,895,850.00
2107	Томилолт, зочны зардал	22,954,400.00	29,156,000.00
210702	Дотоод албан томилолт	22,954,400.00	29,156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	231,550,404.00	477,634,159.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	231,550,404.00	477,634,159.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,093,123,901.23	791,272,839.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	835,045,026.89	466,662,016.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,717,000.00	13,061,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	240,361,874.34	311,549,322.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	425,424,112.39	230,385,143.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,460,859.00	97,303,950.83
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	24,007,200.00

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,970,437.00	56,700,250.83
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,883,422.00	16,596,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,607,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	323,963,253.39	133,081,192.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	323,963,253.39	133,081,192.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,969,189,086.75
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,969,189,086.75
220001	Барилга байгууламж	00.00	90,877,536.00
221001	Их засвар	00.00	1,878,311,550.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	616,184,264.44	1,272,796,644.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	96,000,100.00	94,307,937.93
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	58,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-96,000,100.00	-94,307,937.93
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	520,184,164.44	1,178,488,706.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,545,502,293.00	8,594,726,636.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,545,502,293.00	8,594,726,636.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,573,393.00	2,464,600,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,573,393.00	2,215,196,863.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	249,403,673.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,410,928,900.00	6,130,126,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,410,928,900.00	6,130,126,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,447,761,113.00	6,088,556,245.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,447,761,113.00	6,088,556,245.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,017,039,000.61	5,545,163,808.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,797,713,697.86	2,229,448,711.07
210101	Үндсэн цалин	1,011,955,077.60	1,202,158,941.79
210102	Нэмэгдэл	557,395,700.56	867,042,516.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	105,406,147.38	110,472,334.90
210104	Урамшуулал	122,956,772.32	49,774,918.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,936,974.37	274,106,710.31
210201	Тэтгэврийн даатгал	156,851,434.33	189,027,644.06
210202	Тэтгэмжийн даатгал	18,453,109.93	22,125,230.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,697,417.59	11,183,114.28
210204	Ажилгүйдлийн даатгал	8,387,002.58	10,354,144.29
210205	Эрүүл мэндийн даатгал	33,548,009.94	41,416,577.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,332,137.52	129,766,281.11
210301	Гэрэл, цахилгаан	10,637,734.52	22,577,328.11
210302	Түлш, халаалт	98,134,903.00	102,866,569.00
210303	Цэвэр, бохир ус	4,559,500.00	4,322,384.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,526,967,621.97	1,982,228,050.00
210401	Бичиг хэрэг	23,495,200.00	19,029,500.00
210402	Тээвэр, шатахуун	43,599,202.00	28,230,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,921,696.97	22,927,404.00
210404	Ном, хэвлэл	2,693,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,432,900,000.00	1,898,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,358,523.00	14,041,146.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,260,670.00	82,201,575.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	172,000.00	5,806,000.00
210602	Тавилга	00.00	1,700,000.00

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	127,088,670.00	74,695,575.00
2107	Томилолт, зочны зардал	22,954,400.00	29,156,000.00
210702	Дотоод албан томилолт	22,954,400.00	29,156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	275,846,217.00	373,457,624.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275,846,217.00	373,457,624.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	926,027,281.89	444,798,856.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	911,310,281.89	431,737,356.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,717,000.00	13,061,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	430,722,112.39	543,392,436.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,758,859.00	93,303,950.83
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	20,007,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,970,437.00	56,700,250.83
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,883,422.00	16,596,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,905,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	323,963,253.39	450,088,485.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	323,963,253.39	133,081,192.65
213405	Нэмэлт санхүүжилтын төвлөрүүлэх шилжүүлэг		317,007,293.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	97,741,180.00	2,506,170,390.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	97,741,180.00	2,506,170,390.75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,741,180.00	2,506,170,390.75
2200	Дотоод эх үүсвэрээр	97,741,180.00	2,506,170,390.75
220001	Барилга байгууламж	00.00	90,877,536.00
221001	Их засвар	00.00	2,030,772,954.75
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,741,180.00	384,519,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-97,741,180.00	-2,506,170,390.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,112,092.89	-7,112,092.89
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	1,967,813,910.83	3,209,104,704.78
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	1,967,813,910.83	3,209,104,704.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	1,967,813,910.83	3,209,104,704.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,178,488,706.46	1,178,488,706.46
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	3,146,302,617.29	4,387,593,411.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		6,778,139,200.00	5,997,044,907.35	781,094,292.65	88.5%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,778,139,200.00	5,997,044,907.35	781,094,292.65	88.5%
132001	Орон нутгийн төсвөөс	6,778,139,200.00	5,997,044,907.35	781,094,292.65	88.5%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,778,139,200.00	5,997,044,907.35	781,094,292.65	88.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,778,139,200.00	5,997,044,907.35	781,094,292.65	88.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,691,393,900.00	5,920,337,456.52	771,056,443.48	88.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,265,030,100.00	2,229,448,711.07	35,581,388.93	98.4%
210101	Үндсэн цалин	1,218,611,500.00	1,202,158,941.79	16,452,558.21	98.6%
210102	Нэмэгдэл	877,344,700.00	867,042,516.03	10,302,183.97	98.8%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	119,298,900.00	110,472,334.90	8,826,565.10	92.6%
210104	Урамшуулал	49,775,000.00	49,774,918.35	81.65	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,128,700.00	274,106,710.31	9,021,989.69	96.8%
210201	Тэтгэврийн даатгал	192,527,600.00	189,027,644.06	3,499,955.94	98.2%
210202	Тэтгэмжийн даатгал	22,650,300.00	22,125,230.53	525,069.47	97.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,370,700.00	11,183,114.28	187,585.72	98.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	11,279,500.00	10,354,144.29	925,355.71	91.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	45,300,600.00	41,416,577.15	3,884,022.85	91.4%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,564,700.00	129,766,281.11	5,798,418.89	95.7%
210301	Гэрэл, цахилгаан	22,578,200.00	22,577,328.11	871.89	100.0%
210302	Түлш, халаалт	107,017,700.00	102,866,569.00	4,151,131.00	96.1%
210303	Цэвэр, бохир ус	5,968,800.00	4,322,384.00	1,646,416.00	72.4%
2104	Хангамж, бараа материалын зардал	2,010,307,900.00	1,982,228,050.00	28,079,850.00	98.6%
210401	Бичиг хэрэг	23,115,600.00	19,029,500.00	4,086,100.00	82.3%
210402	Тээвэр, шатахуун	43,600,000.00	28,230,000.00	15,370,000.00	64.7%

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,512,300.00	22,927,404.00	2,584,896.00	89.9%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,898,000,000.00	1,898,000,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,080,000.00	14,041,146.00	6,038,854.00	69.9%
2105	Нормативт зардал	4,000,000.00	00.00	4,000,000.00	0.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	00.00	4,000,000.00	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	263,816,000.00	240,521,475.00	23,294,525.00	91.2%
210601	Багаж, техник, хэрэгсэл	135,816,000.00	134,421,900.00	1,394,100.00	99.0%
210602	Тавилга	33,500,000.00	31,404,000.00	2,096,000.00	93.7%
210604	Урсгал засвар	94,500,000.00	74,695,575.00	19,804,425.00	79.0%
2107	Томилолт, зочны зардал	45,000,000.00	29,156,000.00	15,844,000.00	64.8%
210702	Дотоод албан томилолт	45,000,000.00	29,156,000.00	15,844,000.00	64.8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,037,112,500.00	599,657,624.10	437,454,875.90	57.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,037,112,500.00	599,657,624.10	437,454,875.90	57.8%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	647434000.00	435452604.93	211,981,395.07	67.3%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	627,434,000.00	422,391,104.93	205,042,895.07	67.3%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000,000.00	13,061,500.00	6,938,500.00	65.3%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86745300.00	76707450.83	10,037,849.17	88.4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,745,300.00	76,707,450.83	10,037,849.17	88.4%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	20,007,200.00	9,992,800.00	66.7%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,745,300.00	56,700,250.83	45,049.17	99.9%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70	70	0	100.0%
620001	Удирдах ажилтан	3	3	0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	58	58	0	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	9	9	0	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,147,593,242.75		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,147,593,242.75		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,912,304,248.94		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	235,288,993.81		

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,147,593,242.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,942,752.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,346,252.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9346252.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,346,252.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16596500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,596,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,596,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,121,650,490.75
2200	Дотоод эх үүсвэрээр	2,121,650,490.75
220001	Барилга байгууламж	90,877,536.00
221001	Их засвар	2,030,772,954.75
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 339,595.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 339,595.2 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

Залруулсан алдаа :

1. Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 317,007.3 мянган төгрөгийг авлага үүсгэсэн байхад санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан байна.
2. Нэмэлт санхүүжилтийн дансанд нэр, данс зөрүүтэй 6,280.0 мянган төгрөгийг орлого, зардлаар тайлагнасан байна.
3. Нийгмийн даатгалын байгууллагаас оны эхэнд 3,861.0 мянган төгрөгийн авлагатай бөгөөд тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээгээр 544,652.0 мянган төгрөгийг төлөхөөр мэдээлж 528,021.7 төлж 12,769.3 мянган төгрөгийн өглөгтэй байхад 11,377.0 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд буруу тусгасан байна.
4. Тайлант оны эхэнд Баянхонгор аймгийн Ойн анги -аас өвс тэжээлийн 14,915.6 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд 2025 оны 6 сард тус байгууллагаас 645 шуудай хивэг, тэжээлийг хүлээлгэн өгсөн байхад авлага дансыг хаалгүй үнэ төлбөргүй орлого данс руу буруу бичилт хийсэн байна.

Энэ нь УСНББОУС1-Санхүүгийн тайлангийн толилуулга, Ангилал болон Иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаа тул санхүүгийн тайланд залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 1,079,684.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 211 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, алдаа, зөрчлийг таслан зогсоох 1,079,473.8 мянган төгрөгийн 8 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,079,684.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчлийг санхүүгийн болон нийцлийн гэж хуваасан бөгөөд санхүүгийн аудиттай холбоотой 412,049.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 367,991.8 мянган төгрөгөөр Их тул **Хязгаарлалттай** санал дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын нэрэмжит массын олимпиад зохион байгуулах тухай Сумын Засаг даргын 2024оны 10 дугаар сарын 1-ний өдрийн А/270 дугаар захирамжаар 6,700.0 мянган төгрөг зарцуулахаар баталсан ба гүйцэтгэлээр 6,911.0 мянган төгрөгийн зардал гарч 211.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Илүү зарцуулсан 211.0 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Байгууллагын эзэмшлийн газар нь нягтлан бодох бүртгэлийн үндсэн хөрөнгийн бүртгэлд 6,367 м²-аар бүртгэлтэй байгаа боловч, газрын эзэмших эрхийн гэрчилгээ болон ezaazag.gov.mn цахим санд 21,010 м²-аар бүртгэлтэй байгаа бөгөөд 14,643 м²-аар газрыг байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгээгүй байна

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12 "Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана"- гэсэнтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж бүртгээгүй байгаа газрыг байгууллын биет бус хөрөнгөд бүртгэж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 111/ШШ2022/0006 дугаар шийдвэрийн дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/21 дүгээр захирамжаар Б.Ишмаагийн 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацааны НДШ-ийн 1,236.6 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс нөхөн олгож аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс рүү шилжүүлсэн байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Захиргааны хэргийн Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлж төрд учирсан хохирлыг барагдуулах албан шаардлагыг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод, аудитын газарт хүргүүлэв.

3. Сумын Засаг даргын 2025.05.20-ны өдрийн А/130 захирамжаар мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас Ниншягийн олон улсын найрамдалт хотуудын 4 дүгээр форумд оролцоход тийз, замын зардалд 14,971.7 мянга, бэлэг сэлтийн зардалд 12,450.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалт "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн хөрөнгөөс гадаад арга хэмжээний зардалд зарцуулахгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

4.Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Сумын Засаг даргын 6 удаагийн захирамжаар нийт 17,457.5 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

5. Баянхонгор сумын ИТХ-аас ЗДТГ-т автомашин худалдан авахад 150,000.0 мянган төгрөг баталсан боловч 186,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 36,700.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

6. Аймгийн Замын сангаас эрх шилжүүлсэн Баянхонгор сумын А зэрэглэлийн бүсийн тоосжилтыг бууруулах зорилгоор шаардлагатай газруудад хучилт хийх 165,770.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг 9 иргэнтэй, мөн "Нэгдсэн эмнэлгийн гадна зогсоолын засвар" 200,000.0 мянган төгрөгийн төсөвт

өртөгтэй төслийг 9 аж ахуйн нэгжтэй тендер зарлалгүй тус бүр 20,000. Мянган төгрөгөөр шууд гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Замын сангаар хэрэгжих төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн хэрэгжүүлдэг байдлыг таслан зогсоох, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө, оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.

7. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх 130,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор сумын 10 дугаар багийн 301, 303, 511, 109 дүгээр байрны гадна фасад, дээврийн засвар"-ын ажлын эрхийг суманд шилжүүлж санхүүжилтийг ЗДТГ-ын нэмэлт дансанд олгосон бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулж "Би би ди эм эм" ХХК-тай 301 дүгээр байрыг 39,991.7 мянга, 511 дүгээр байрыг 49,999.9 сая, 109 дүгээр байрыг 87,598.9 мянга нийт 47,590.5 мянга төгрөгөөр илүү үнийн дүнгээр гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн хэрэгжүүлдэг байдлыг таслан зогсоох, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн Хөрөнгө, оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.

8. Сумын ЗДТГ-ын 2025.10.21-ны өдрийн Б/103 дугаар тушаалаар ёс зүйн хорооны урамшуулал 3,960.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлснөөс ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

5.2.1. Нягтлан бодогч цалингийн зардлыг нягтлан бодох бүртгэлд бичихдээ мөнгөн сууриар бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө." гэсэн заалт, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга-тай нийцэхгүй байна.

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нягтлан бодох бүртгэлийн программтай холбон бичилтийг хийж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 317,007.3 мянган төгрөгийг авлага үүсгэсэн байхад санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан байна.	1	317,007.3			1	317,007.3	1	317,007.3				
Нэмэлт санхүүжилтийн дансанд нэр, данс зөрүүтэй 6,280.0 мянган төгрөгийг орлого, зардлаар тайлагнасан байна.	1	6,280.0			1	6,280.0	1	6,280.0				
Санхүүгийн тайланд 1,392.3 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийг дутуу тусгасан байна.	1	1,392.3	1	1,392.3			1	1,392.3				
4. Тайлант оны эхэнд Баянхонгор аймгийн Ойн анги -аас өвс тэжээлийн 14,915.6 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд 2025 оны 6 сард тус байгууллагаас 645 шуудай хивэг, тэжээлийг хүлээлгэн өгсөн байхад авлага дансыг хаалгүй үнэ төлбөргүй орлого данс руу буруу бичилт хийсэн байна.	1	14,915.6			1	14,915.6	1	14,915.6				
Нийт дүн	4	339,595.2	1	1,392.3	3	338,202.9	4	339,595.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын Засаг даргын нэрэмжит массын олимпиад зохион байгуулах тухай Сумын Засаг даргын 2024оны 10 дугаар сарын 1-ний өдрийн А/270 дугаар захирамжаар 6,700.0 мянган төгрөг зарцуулахаар баталсан ба гүйцэтгэлээр 6,911.0 мянган төгрөгийн зардал гарч 211.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.	1	211.0	1	211.0				
Байгууллагын эзэмшлийн газар нь нягтлан бодох бүртгэлийн үндсэн хөрөнгийн бүртгэлд 6,367 м ² -аар бүртгэлтэй байгаа боловч, газрын	1	0			1	0		

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

эзэмших эрхийн гэрчилгээ болон egazar.gov.mn цахим санд 21,010 м²-аар бүртгэлтэй байгаа бөгөөд 14,643 м²-аар газрыг байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгээгүй байна								
Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 111/ШШ2022/0006 дугаар шийдвэрийн дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/21 дүгээр захирамжаар Б.Ишмаагийн 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацааны НДШ-ийн 1,236.6 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс нөхөн олгож аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс рүү шилжүүлсэн байна.	1	1,236.6			1	1,236.6		
Тайлант оны жилийн эцсийн байдлаар ашиглалтын хугацаа дууссан 166 нэр төрлийн 426 ширхэг 411,049.7 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бөгөөд тухайн хөрөнгийг дахин үнэлгээ хийх болон актлах асуудлыг шийдвэрлээгүй байна.	1	411,049.7			1	411,049.7		
Нягтлан бодогч цалингийн зардлыг нягтлан бодох бүртгэлд бичихдээ мөнгөн сууриар бүртгэсэн.	1	0					1	0
Дүн	5	412,497.3	1	211.0	3	412,286.3	1	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс биеийн тамир уралдаан тэмцээн зохион байгуулахад тайлант онд 17,457.5 төгрөгийг зарцуулсан байна.	1	17,457.5	1	17,457.5		
Баянхонгор сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2/14 дүгээр тогтоолоор 2025 онд ЗДТГ-т автомашин худалдан авахад 150,000.0 мянган төгрөг баталсан боловч, худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2025.05.09-нд "Бүдүма" ХХК-тай 186,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2025.06.02-нд Alphard-35, Prius-41, Alphard-25 автомашинуудыг хүлээн авч, үүнээс Alphard-25-ыг аймгийн Татварын газарт, Prius-41-ийг аймгийн Цагдаагийн газарт тус тус хүлээлгэн өгсөн байна.	1	150,000.0	1	150,000.0		
Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж нэмэлт санхүүжилтийн дансанд олгосны хүрээнд 165,770.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор сумын А зэрэглэлийн бүсийн тоосжилтыг бууруулах зорилгоор шаардлагатай газруудад хучилт хийх" төслийг 9 иргэнтэй, мөн 200,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Нэгдсэн эмнэлгийн гадна зогсоолын засвар" төслийг 9 аж ахуйн нэгжтэй тус тус тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.	1	365,770.0	1	365,770.0		
Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх 130,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор сумын 10 дугаар багийн 301, 303, 511, 109 дүгээр байрны гадна фасад, дээврийн засвар"-ын ажлын эрхийг суманд шилжүүлж санхүүжилтийг ЗДТГ-ын нэмэлт дансанд олгосон бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулж "Би би ди эм эм" ХХК-тай 301 дүгээр байрыг 39,991.7 мянга, 511 дүгээр байрыг 49,999.9 сая, 109 дүгээр байрыг 87,598.9 мянга нийт 47,590.5 мянга төгрөгөөр илүү үнийн дүнгээр гэрээ байгуулсан байна.	1	130,000.0	1	130,000.0		
Сумын Засаг даргын 2025.05.20-ны өдрийн А/130 захирамжаар мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас Нишягийн олон улсын найрамдалт хотуудын 4 дүгээр форумд оролцоход тийз, замын зардалд 14,971.7 мянга, бэлэг сэлтийн зардалд 12,450.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна	1	25,931.5	1	25,931.5		
Сумын ЗДТГ-ын 2025.10.21-ны өдрийн Б/103 дугаар тушаалаар ёс зүйн хорооны урамшуулал 3,960.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	3,960.0	1	3,960.0		
Дүн	5	667,187.5	5	667,187.5		

-----oOo-----